



Я.САРАНСҮХ

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН ГАРГАСАН ҮНЭТ ЦААС, БОНД ГАРГАЛТ, БОНДЫН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ ЭСЭХЭД ДУГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 05 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар
22-020

Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛГО

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2018-2021 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийж буй гүйцэтгэлийн аудитын хурээнд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гаргасан үнэт цаас, бонд, тэдгээрээс төвлөрсөн хөрөнгийн зарцуулалт үр нөлөөтэй байгаа эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Шинжээч нь гэрээ байгуулснаас эхлэн тайлагналын үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

Эхлэх хугацаа: 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Дуусах хугацаа: 2022 оны 09 дугаар сарын 15-ны өдөр

Байршил: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо.
Жигжиджавын гудамж-8 Финанс төв

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Терийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1¹, 17.2², Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэл, Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 4/233 дугаар албан бичиг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/53, 2021 оны A/28, 2022 оны A/12 дугаар тушаалуудаар баталсан Үндэсний аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөнд үндэслэн хийж буй “Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2018-2021 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт” сэдэвт гүйцэтгэлийн аудитад мэдлэг, ур чадвар бүхий этгээдийг хөндлөнгийн шинжээчээр татан оролцуулна.

ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь Эрдэнэс Тавантолгой ХК болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг бүрэн хамруулж дүгнэлт гаргана.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн санхүүгийн тайлан, эдийн засгийн үзүүлэлт, бусад холбогдох баримт материалыд үндэслэн судалгаа, дун шинжилгээ хийж, дараах

¹ Терийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно.

² Шинжээч аудитыг хийхэд шаардагдах тодорхой ажлыг гүйцэтгэх мэдлэг, ур чадвартай этгээд байна.

асуудлаар мэргэжлийн, нотлох баримтаар баталгаажсан дүгнэлт, зөвлөмж гаргахын зэрэгцээ аудитын талбарын болон тайлагналын үе шатны үйл ажиллагаанд хариуцсан асуудлаар аудитын багийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангана. Үүнд:

Д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн үнэт цаасны арилжаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгө, түүний зарцуулалт, бондын өгөөж болон ашиглалтын үр нөлөөт байдалд дүгнэлт гаргах	Урьдчилсан судалгааны явцад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн ашиглалт, үр нөлөөг сайжруулах зөвлөмж боловсруулах	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн ашиглалт, үр нөлөөг сайжруулах зөвлөмж боловсруулах	<ul style="list-style-type: none"> - А6-20 стратегийн баримт бичиг, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах төлөвлөгөө; - ТУЗ-өөс баталсан жил бурийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл; - Батлагдсан ТЭЗҮ-д тусгасан төсөл, хөтөлбөр;
2	Гадаад улс, орнуудын нүүрсний орд ашиглалтын сайн туршлагыг судлах, түүнийг Тавантолгой болон манай орны бусад нүүрсний орд ашиглалттай харьцуулж дүгнэлт гаргах	Урьдчилсан судалгааны явцад Тавантолгойн ордын ашиглалтаас олох үр ашиг, өгөөж буурсан.	Тавантолгой ордын ашиглалтын үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, зөвлөмж боловсруулах.	<ul style="list-style-type: none"> - Олон улсад ашиглаж байгаа ижил төстэй уурхайн сайн жишээ
3	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн үйл ажиллагаанд мөрдөж буй дүрэм, журмууд Олон улсын жишигийн дагуу зардлыг үр ашигтай удирдах тогтолцоог бүрдүүлж чадаж буй эсэх, гадаад валютын ханшийн өөрчлөлтийг үр нөлөөтэй удирдаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах	Урьдчилсан судалгааны явцад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ургсал болон хөрөнгийн зардлыг оновчтой төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, дотоодод мөрдөж буй дүрэм, журмууд байнга өөрчлөгддөг эсвэл хуучирсан байдаг.	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн санхүүгийн менежмент, хөрөнгийн удирдлагыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> - Компанийн тухай хууль; - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; - ТБОНХБАУХАТХ; - Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоол; - А6-20 стратегийн баримт бичиг; - ТУЗ-өөс баталсан жил бурийн үйл ажиллагааны төлөвлөгөө; - Батлагдсан ТЭЗҮ; - Бусад дүрэм, журмуудын холбогдох заалт.
4	Валютын ханшийн өөрчлөлт, КОВИД-19 цар тахал зэрэг гадаад хүчин зүйлсийн компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн нөлөөллийн талаар дүгнэлт гаргах	2010-2022 онд гадаад хүчин зүйлсээс нөлөөллөөс шалтгаалж, компанийн үйл ажиллагааны үр ашиг буурч байна.	Гадаад хүчин зүйлсээс болж компанийн үйл ажиллагаанд нөлөөлж буй нөлөөллийг бууруулах, эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	<ul style="list-style-type: none"> - Дэлхийн банк, ОУВС, Азийн хөгжлийн банк, Монголбанкнаас гаргадаг жил бурийн судалгаа, шинжилгээний үр дүн; - Эрдэнэс Тавантолгой ХК-ийн санхүүгийн үзүүлэлтүүд; - Бусад холбогдох судалгаа.
5	Нэмэлт шаардлага: Тухайн гүйцэтгэх ажил, үүргийн хүрээнд нэмэлт ажил хийх тохиолдолд гүйцэтгэх ажил үүрэг бүрээр нэмэлт ажил оруулах боломжтой.			
	Гүйцэтгэх нийт ажлын хүрээнд цаашид авах арга хэмжээ, засаж сайжруулах талаар тодорхой дүгнэлт гаргах.			

ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ

- Шинжээчийн ажлын тайлан нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зайд “single” үсгийн хэмжээ 11-12/ байх бөгөөд холбогдох тооцоо, судалгааг хавсралтаар бэлтгэсэн байна.
- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж, ном, хэвлэл, Олон Улсын Аудитын дээд байгууллагаас гаргасан тунхаглал, Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын стандарт мэдээлэл зэрэг эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын зорилт үр нөлөөтэй байгаа эсэхийг хянан үзэж дүгнэлт гарган, үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ажлын даалгаварт заасан зорилго, зорилтын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах шинжээч болон шинжээчийн баг нь компанийн санхүүгийн үйл ажиллагаа, олон улсын чиг хандлагын талаар өргөн мэдлэгтэй, зохих мэдээллийн сан бүрдүүлсэн, макро эдийн засаг, төсөв, санхүү, бизнес, гэрээ хэлцлийн талаар зохих мэдлэгтэй, судалгаа, шинжилгээ тооцоолол, дүгнэлт гаргах чадвартай иргэн, хуулийн этгээд /түншлэл/ байж болно.

Шинжээчээр ажиллах хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан боловсон хүчинтэй байна. Үүнд:

- Олон Улсын санхүү, эдийн засгийн чиглэлээр суралцаж төгссөн, эдийн засагч мэргэжилтэй, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй 2 буюу түүнээс дээш ажилтантай;
- Санхүү, банк, аудитын байгууллагад 10 буюу түүнээс дээш жил ажилласан, судалгаа, шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;

Шинжээчээр ажиллах иргэн, баг нь дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай ажилтантай байна. Үүнд:

- Олон Улсын санхүү, эдийн засгийн чиглэлээр суралцаж төгссөн, эдийн засагч мэргэжилтэй, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй;
- Санхүү, банк, аудитын байгууллагад 10 буюу түүнээс дээш жил ажилласан, судалгаа, шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;
- Салбарын мэргэшсэн эсвэл зөвлөх зэрэгтэй бол давуу тал болно.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын албан хаагчийн мөрдөх ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-д заасны дагуу олон улсын санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийг аудитад татан оролцуулах шаардлага үүссэн.

Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дутгуйлсан байх) ;

Дээрх шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлж, цуглуулсан бүх баримт, мэдээлэл, зөвлөмжийг хавсаргана.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

ДОЛОО. БУСАД

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын аудитын баг бүрэлдэхүүнтэй хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас авч болно.

Ажлын даалгаварт тусгасан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан шинжээч нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндэрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Аудитын гуравдугаар газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.